



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/108

Алтай хот

**Үндэсний бичгийг албан хэрэгцээнд
нэвтрүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалт, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 96 дугаар тогтоолоор баталсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III", аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Төрийн байгууллагын албан хаагчдад явуулах үндэсний бичгийн цахим бичвэрийн сургалтын хуваарийг нэгдүгээр хавсралтаар, уралдааны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар, шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар, сургалтын хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
- 2.Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаяг, төрийн албан хаагчийн нэрийн хуудсыг батлагдсан стандарт (MNS 5283:2022, MNS 6978:2022)-ын дагуу хэвлүүлж хэрэглэхийг байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
- 3.Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS 6395:2022 стандартын дагуу захирамжлалын баримт бичиг, явуулж буй албан бичгийг 05 дугаар сарын 01-ний өдрөөс хос бичгээр үйлдэж баталгаажуулахыг төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
- 4.Сургалтад шаардагдах 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийн зардлыг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.
- 5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, үр дүнг Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч Хэлний бодлогын салбар зөвлөл (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 04
дугаар сарын 12-ны өдрийн 4/12 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ҮНДЭСНИЙ БИЧГИЙН ЦАХИМ БИЧВЭРИЙН
СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Үндэслэл: Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.2, 17.1.3 дахь заалт, "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ыг хэрэгжүүлнэ.

Зорилго: Төрийн албан хаагчдад цахимд монгол бичгээр бичих чадвар эзэмшүүлж, үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.

Зохион байгуулах үйл ажиллагаа:

Төрийн албан хаагчдад зориулсан үндэсний бичгийн цахим бичвэрийн 1 цагийн танхимын сургалтыг хуваарийн дагуу монгол хэл, уран зохиолын тэргүүлэх багш Д.Мөнхцэцэг хөтлөн явуулна. (Байгууллагуудын хамрагдах хуваарийг хавсаргав)

-Компьютерт монгол бичгийн программ суулгах;

-Гарын байрлал, бичих арга зүй таниулах;

-Дадлага ажил, бие даалт хийлгэх;

Зохион байгуулагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Насан туршийн боловсролын төв

Хамрах хүрээ: Төрийн байгууллагын албан хаагчид хамрагдана.

Хугацаа: 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 04 дүгээр сарын 28-ны өдрийн хооронд зохион байгуулна.

Анхаарах зүйлс: Байгууллагын удирдлага нь сургалтын хуваарьт өдөр албан хаагчдыг бүрэн хамруулахаар ажлаа төлөвлөж, цагийн менежмент хийнэ.

-Сургалтад хамрагдах албан хаагч бүр компьютертэй байх;

-Сургалтын дараах бие даалтыг чанартай хийж байгууллагын хариуцсан ажилтанд шалгуулах;

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дугаар сарын 12 ны өдрийн 01/198 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ҮНДЭСНИЙ БИЧГИЙГ ХЭРЭГЛЭХ, НЭВТРҮҮЛЭХ
"ЦАХИМ МОНГОЛ БИЧИГ" УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Үндэслэл:

Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.2, 17.1.3 дахь заалт, Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлнэ.

Нэг. Зорилго:

Төрийн албан хаагчдын цахимд монгол бичгээр зөв, хурдан бичих чадварыг сайжруулан, үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, албан хаагчдыг дэмжиж урамшуулна.

Хоёр. Зохион байгуулалт:

1. Байгууллагуудад орсон үндэсний бичгийн цахим бичвэрийн сургалтаар бие дааж шивэх эхүүдийг өгнө. Тухайн эхүүдээс уралдааны даалгаварт оруулна.
2. Тодорхой хугацаанд компьютерт монгол бичгээр хамгийн олон үгийг зөв шивсэн үзүүлэлтээр шалгаруулна.
3. Сургалтаар эзэмшүүлсэн MONGOLIAN BAITI фонтоор шивүүлнэ.

Гурав. Зохион байгуулагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Насан туршийн боловсролын төв

Дөрөв. Ангилал:

1. Төрийн албан хаагчид (Байгууллагаас 1-2 хүн)
2. Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтан (Бүх байгууллагын бичиг хэргийн ажилтнууд заавал оролцоно) гэсэн ангиллаар зохион байгуулна.

Тав. Хамрах хүрээ:

Төрийн албан хаагч, архив бичиг хэргийн ажилтнуудыг хамруулна.

Зургаа. Хугацаа:

2023 оны 5 сарын эхний 7 хоногт зохион байгуулна. (Уралдаан зохион байгуулагдах газрыг тухайн үед шийдвэрлэж зарлана)


Долоо. Шагнал урамшуулал:

Тэргүүн байр 2, өргөмжлөл 400,000 төгрөг

Дэд байр 2, өргөмжлөл 300,000 төгрөг

Гутгаар байр 2, өргөмжлөл 200,000 төгрөг

Аймгийн Засаг даргын 2023 оны 04
дугаар сарын 10 ны өдрийн 01/198 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Нэгжийн дүн	Тоо хэмжээ	Нийт дүн
1	Монгол бичгээр цахимд бичих сургалтын сургагч багшийн хөлс	1,000,000	1	1,000,000
2	Монгол бичгийн багш нарыг чадавхжуулах сургалтын зохион байгуулалтын зардал	760,000	1	760,000
3	Сургагч багш бэлтгэх сургалтын батламж, хэрэглэгдэхүүний зардал	200,000	1	200,000
4	Аяны зохион байгуулалтад шаардагдах бусад зардал	2,040,000	-	2,040,000
Нийт дүн				4,000,000

__оОо__

